

Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 52 дугаар хуралдаанаар хэлэлцэн, Үндэсний зөвлөлийн 19 дүгээр эчнээ хуралдаанаас гишүүдийн гаргасан саналыг оруулан батлав.

“ОУИТБ ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ, ОУИТБС-ЫГ СУРТАЛЧЛАХ, ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ” УРИА БҮХИЙ 2021 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэгдүгээр зорилго: “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль”-ийн төслийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, батлуулах; Үндэслэл: Монгол Улсыг 2018 оны 2 дугаар сард дэлхий дахинаа ОУИТБС-ын стандартыг бүрэн хангасан хоёрдогч орноор зарласан билээ. Гэсэн хэдий ч 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ашиг хүртэгч жинхэнэ эздийг ил тод болгох, гэрээний ил тод байдлыг бүрэн хангах, авилгалын эрсдэлийг бууруулах, төрийн байгууллагуудын системээр санхүүгийн бус мэдээллийг тогтмол ил тод болгох зэрэг томоохон зорилтуудыг хангах шаардлага байсаар байна. Монгол Улсад 2007-2020 оныг дуустал 12 жилийн хугацаанд ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлэхэд хандивлагч орнууд, Дэлхийн банк, АХБ зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагааг санхүүжүүлэн буцалтгүй тусламжийг үзүүлж ирсэн ч цаашид тэдний зүгээс ОУИТБС-ыг Монгол Улсын Засгийн газар манлайлан авч явж, санхүүжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа билээ. Иймд урт хугацаанд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд санхүүгийн болон институтын тогтвортой байдлыг хангах, үр нөлөөг улам нэмэгдүүлэх, баталгаажуулах үүднээс “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай” бие даасан хуультай болох шаардлагатай юм.										
Хянан зохицуулах байгууллага: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам										
ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА	ТӨСӨВ		Тайлбар	Хяналт тавих байгууллага	Биелэлт	
					Мөнгөн дүн (мян.төг)	Эх үүсвэр				
Зорилт 1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, эцэслэх;	1.1. Хуулийн ажлын хэсгийг үргэлжлүүлэн ажиллуулах;	Хуулийн төслийг боловсруулах, батлуулах үйл явц хангагдана	УУХҮЯ, Ажлын алба	1-9 дүгээр сар	-	-		УУХҮЯ	Хуулийн ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Дэд хэсэг 13 удаа хуралдсан.	
	1.2. Олон улсын болон дотоодын зөвлөхийг ажиллуулж, хуулийн төслийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах;	Хуулийн төсөлд олон улсын туршлага, стандартыг нэвтрүүлсэн байна	Хуулийн ажлын хэсэг, Ажлын алба	Хуулийн ажлын хэсэг, Ажлын алба	1-3 дугаар сар	-	АХБ	АХБ-аас гадаад, дотоод зөвлөх ажиллуулна.	УУХҮЯ	Гадаад, дотоодын зөвлөхийг АХБ-ны санхүүжилтээр ажиллуулж хуулийн төслийг бэлтгэсэн.
	1.3. Олон нийтийн хэлэлцүүлгүүдийг цахимаар болон танхимаар зохион байгуулах;	Хуулийн төсөл бэлэн болсон байна.	Хуулийн ажлын хэсэг	Хуулийн ажлын хэсэг	4 дүгээр сар	-	-		УУХҮЯ	Төв, Баруун болон Зүүн бүсийн ОУИТБС-ын чуулганд төслийг танилцуулсан.
	1.4. ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, УУХҮ-ийн сайдын зөвлөлөөр хуулийн төслийг хэлэлцүүлж, эцэслэх	Хуулийн төслийг яамдаас санал авахад бэлэн болсон байна.	Хуулийн ажлын хэсэг	Хуулийн ажлын хэсэг	5 дугаар сар	-	-		УУХҮЯ	Хуулийн төслийг 6-р сард бэлэн болгосон.
Зорилт 2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барих, батлуулах, хэрэгжүүлэх ажлын бэлтгэлийг хангах;	2.1. Хуулийн төсөлд яамдын саналыг авч, эцэслэх;	Яамдаас ирүүлсэн саналыг тусгасан байна.	УУХҮЯ, Хуулийн ажлын хэсэг	6 дугаар сар	-	-		УУХҮЯ	Хүлээгдэж байна.	
	2.2. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах;	Засгийн газраас гарсан саналыг тусгасан байна	УУХҮЯ, Хуулийн ажлын хэсэг	УУХҮЯ, Хуулийн ажлын хэсэг	6 дугаар сар	-	-		УУХҮЯ	Хүлээгдэж байна.
	2.3. Хуулийн төслийг УИХ-д өргөн барихын өмнө УИХ-ын Төсвийн болон Эдийн засгийн, БО-ны байнгын хороонд ОУИТБС-ыг хэрэгжүүлж ирсэн тухай, түүний ач холбогдолыг ойлгуулах мэдээлэл өгөх зөвлөлдөх уулзалтуудыг хийх;	Хуулийн төсөл бэлэн болсон байна.	УУХҮЯ	УУХҮЯ	6 дугаар сар	5,000	Улсын төсөв		УУХҮЯ	2021-11-16-нд УИХ дээр хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулах байсан, хойшлогдсон..
	2.4. Хуулийн төсөл УИХ-д өргөн баригдахын өмнө болон хэлэлцэх явцад, хууль батлагдсаны дараах бүх шатанд хуулийн ач холбогдлыг	Хуулийн ач холбогдлын талаарх олон нийтийн	УУХҮЯ, Ажлын алба	УУХҮЯ, Ажлын алба	6 дугаар сар	10,000	Улсын төсөв		УУХҮЯ	Хүлээгдэж байна.

	хэвлэл, мэдээллээр танилцуулан сурталчлах;	ойлголт нэмэгдсэн байна.								
	2.5. Хуулийн төслийг УИХ-д өргөн барих, батлуулах;	Хуулийн төсөл батлагдсан байна.	УУХҮЯ	6 дугаар сар	-	-		УУХҮЯ	2021 оны намрын чуулганы хэлэлцэх жагсаалтад оруулж тогтоол гарсан байна.	
	2.6. Батлагдсан хуулийг хэрэгжүүлэх ¹ бэлтгэл ажлыг хангах;	Хэрэгжүүлэх бэлтгэл хангагдана.	Ажлын алба	7-11 дугаар сар	5,000	Улсын төсөв		УУХҮЯ	Хүлээгдэж байна.	
Нэгдүгээр зорилгод шаардагдах мөнгөн дүн							Улсын төсөв			

Хоёрдугаар зорилго: ОУИТБС-ын стандартын дагуу компаниуд, төрийн байгууллагууд олон нийтэд зориулсан сүлжээгээр ил тод болгох ажлыг системтэйгээр хэвшүүлэх, тайлан гаргах үйл явцыг эрчимжүүлэх, компани, төрийн байгууллагуудын тайлагналын оролцоог нэмэгдүүлэх.

Үндэслэл: ОУИТБС-ын Олон улсын Удирдах хорооноос 2019 онд гишүүн бүх орнуудад шинэ стандартад шилжих зөвлөмжийг хүргүүлж, түүнд үндэслэн тайлангийн маягтуудыг шинэчлэн боловсруулж, компаниудад мөрдүүлж эхлээд байгаа билээ. Ач холбогдол нь төрийн байгууллагууд, тэргүүлэх компаниуд стандартын дагуу ил тод байдлыг үйл ажиллагаандаа хангах, хэвшүүлэх, шинэ шаардлагуудыг хэрэгжүүлэх, нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа ойлгомжтой болгох, улмаар хариуцлагатай байдлыг сайжруулахад оршино. ОУИТБС-ын тайланг цахимаар жил бүр 2100 гаруй компаниуд гаргах ёстой хэдий боловч дунджаар 1450 гаруй компани тайлангаа гаргаж 600 гаруй компаниуд тайлан гаргахгүй байх тохиолдол байна. Иймд тайлан гаргах үйл явцыг эрчимжүүлэх, компаниудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлд тодорхой бодлого, арга хэмжээ авч ажиллах шаардлага үүсч байна. Мөн хариуцлагын тогтолцоо бий болгох, хариуцлага тооцох төрийн байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэх шаардлага нэн чухал байна.

Хянан зохицуулах байгууллага: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА	ХУГАЦАА	ТӨСӨВ		Тайлбар	Хяналт тавих байгууллага	Биелэлт
					Мөнгөн дүн (мян.төг)	Эх үүсвэр			
Зорилт 3. ОУИТБС-ын шинэ стандартын шаардлагуудыг хангах, тайлангийн системийг шинэчлэх, төрийн байгууллага, эрдэс баялгийн салбарт төсөл хэрэгжүүлж буй компаниуд 100% тайлангаа гаргах;	3.1. ОУИТБС-ын мэдээлэл, тайланг бусад улсад хэрхэн хийж байгаа талаар болон ямар программ хангамж ашиглаж байгаа талаар судлах, цахим системийг хялбаршуулж, компани, төрийн байгууллагуудад илүү ойлгомжтой болгох, цахим тайлангийн сайтыг шинэчлэн засварлах;	Цахим систем илүү ойлгомжтой, тайлан гаргахад хялбар болсон байна	Ажлын алба	1-3 дугаар сар	30,000	Бусад эх үүсвэр	Системийн шинэчлэлийн ажлын зардал.	УУХҮЯ	Тендерээр Лидер Визин групп ХХК шалгарч, гэрээ байгуулан ажил явагдан дууссан. Зардал-27,500.0 төгрөг Ажлын албаны вэбхуудсыг сайжруулах ажлын Содон Солюшн ХХК-тай гэрээ хийж гүйцэтгүүлсэн. Ажлын хүлээлцэх шатандаа байна. Зардал-3,300.0 төгрөг.
	3.2. Шинэчлэгдсэн маягтуудын дагуу компаниудад аргагүйн сургалтыг цахимаар зохион байгуулах;	Компаниудын удирдлага, мэргэжилтнүүд мэдлэгтэй болно.	Ажлын алба	2-3 дугаар сар	-	-		УУХҮЯ	4 удаагийн цахим сургалт зохион байгуулсан. 100 гаруй компани оролцсон

¹ Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тусад нь гаргах:

	3.3. Компаниуд тайлангаа идэвхтэй гаргах, компаниудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тусгайлан бодлого хэрэгжүүлэх, хариуцлагын тогтолцоо бий болгож хэрэгжүүлэх, ажлыг зохион байгуулах;	Компаниудын тайлагналт 90 хувьд хүрсэн байна.	Ажлын алба	1-3 дугаар сар	-	-		УУХҮЯ	6-р сарын 1-нээр 1419 компани ОУИТБС-ын цахим системээр тайлангаа илгээсэн
	3.4. Компани, аж ахуйн нэгжүүд, холбогдох бүх шатны төрийн байгууллагууд ОУИТБС-ын цахим тайлагналын системээр тайлан гаргах;	Тайлангууд гарсан байна.	Тайлан гаргах үүрэг бүхий төрийн байгууллагууд, компаниуд	3-6 дугаар сар	1,000	Улсын төсөв	Тайлан гаргагчид зөвөлгөө өгөх холбооны зардал.	МХЕГ	6-р сарын 1-нээр 18 аймаг, 6 дүүрэг, 7 агентлаг 1650 компаниас орлого хүлээж авснаа цахимаар тайлагнасан.
	3.5. Ажлын албаны техникийг шинэчилж, цахим тайланг хурдан шуурхай гаргах боломжийг бүрдүүлэх;	Тайлан хурдан шуурхай гарах нөхцөл бүрдэнэ.	Ажлын алба	3-5 дугаар сар	20,000	Бусад эх үүсвэр	Чадал сайтай компьютер авах	УУХҮЯ	3 лаптоп худалдан авсан..
Зорилт 4. Хэвшүүлэн ил тод болгох талаар төрийн байгууллагын мэргэжилтнүүдийн мэдлэг, ойлголт, чадавхийг нэмэгдүүлэх;	4.1. СЯ, АМГТГ, ТЕГ, ГЕГ, НДЕГ, ХХҮГ, ТӨБЗГ-ын ажилтнуудад зориулсан сургалт, дадлага ажил зохион байгуулах- цахим;	Нэр дурдсан байгууллагын ажилтнуудын мэдлэг, ойлголт сайжирсан байна.	Ажлын алба	2-6 дугаар сар	-	-	2020 оноос шилжсэн.	УУХҮЯ	СЯ-тай хэлэлцсэн, хариу хүлээж байна.
	4.2. Орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт, дадлага ажил зохион байгуулах- цахим;	Нэр дурдсан байгууллагын ажилтнуудын мэдлэг, ойлголт сайжирсан байна.	Ажлын алба	3-4 дүгээр сар	-	-	2020 оноос шилжсэн.	УУХҮЯ	Аймгуудын Дэд зөвлөлүүдтэй 2 сар тутам цахимаар уулзаж, энэ үеэр мэдээлэл өгөхийн хамт сургалт зөвөлгөөг өгч байна.
Зорилт 5. Системтэйгээр ил тод болгох шаардлагатай мэдээллийн сангуудыг бий болгох, сайжруулах;	5.1. Кадастрын системд ОУИТБС-ын стандартаар шаардсан өргөдлийн огноо, Бүтээгдэхүүн хуваах гэрээний талбайн солбилцол, сонгон шалгаруулалтын үр дүн, цуцалсан тухай мэдээллийг оруулах, ил тод болгох;	Стандартаар шаардсан тусгай зөвшөөрлийн бүртгэл, олголт, БХГ-тэй холбоотой мэдээлэл ил тод болсон байна.	АМГТГ	1-4 дүгээр сар	-	-	2019 оноос шилжсэн, АМГТГ цахим сайт дээрээ байрлуулна.	УУХҮЯ	УУХҮЯ-наас албан тоотыг АМГТГ-т явуулж, үүрэг даалгаврыг хүргүүлсэн.
	5.2. Төрийн өмчийн компаниудын цахим тайлагналын системд стандартын дагуу нэмэлт мэдээлэл оруулах, тайлан гаргуулах, хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх;	Стандартаар шаардсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой мэдээлэл ил тод болно. ТӨК иудын манлайлал нэмэгдсэн байна.	ТӨБЗГ, Эрдэнэс Монгол ХХК, Ажлын алба	3-4 дүгээр сар	-	-	ТӨК тайлангаа гаргаж, цахим сайт дээрээ байршуулна.	УУХҮЯ	4 удаагийн цахим сургалтад 100 гаруй компанийн төлөөлөл оролцсоны дотор Эрдэнэт, Эрдэнэс Таван толгой ХХК-ийн төлөөлөл оролцсон
	5.3. Төрийн өмчийн компаниуд стандартын дагуу жилийн санхүүгийн тайлангаа хэвлэн нийтлэх, тайлангийн формат, удирдамж боловсруулах;	Стандартаар шаардсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой мэдээлэл ил тод болно.	ТӨБЗГ, Эрдэнэс Монгол ХХК, Ажлын алба	4-6 дугаар сар	-	-	ТӨК тайлангаа гаргаж, цахим хуудас дээрээ байршуулна.	УУХҮЯ	Эрдэнэс Монгол ХХК дээр сургалт хийхээр хэлэлцэж, хариу хүлээж байна.

Зорилт 6. Гэрээний ил тод байдлыг 2021 оны 1 дүгээр сарын 1-нээр хангах;	6.1. Гэрээ байгуулахын өмнө Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа хийх замаар гэрээний эрх зүйн чадамжийг хангах, нөлөөллийг төрийн байгууллагуудад хүргүүлэх, АМГТГ гэрээний тайлан авах формат гаргаж өгөх;	Стандартын шаардлагыг хангана.	УУХҮЯ, СЯ, Аймгийн ЗДТГ-ууд	1-6 дугаар сар	-	-	2020 оноос шилжсэн, УУХҮЯ, Аймгуудын ЗДТГ цахим сайт дээрээ байршуулна.	ИНБ АМГТГ	Холбогдох албан тоотыг АМГТГ-т хүргүүлсэн хариу ирээгүй байна.
	6.2. 2018-2019 онд байгуулагдсан гэрээнүүдийг www.iltodgeree.mn сайтад байршуулах, мониторинг хийж дүгнэлт гаргах;	Стандартын шаардлагыг хангана.	Гэрээ байгуулсан холбогдох байгууллагууд, Нээлттэй нийгэм хүрээлэн	2-9 дүгээр сар	-	-		УУХҮЯ, Ажлын алба, ИНБ	Орон нутгийн гэрээний хэлэлцүүлгийг 5-р сарын 19-нд зохион байгуулсан. Эрдсийн баялгийн гэрээний сангийн журмын тушаалыг УУХҮЯ-наас 9-р сард баталсан. Аймгуудад сургалт зохион байгуулсан.
	6.3. Төрийн өмчийн компаниудын худалдааны гэрээнүүдийг www.iltodgeree.mn сайтад байршуулах, мониторинг хийж дүгнэлт гаргах;	Стандартын шаардлагыг хангана.	ТӨБЗГ, Эрдэнэс Монгол ХХК, ИНБ	2-9 дүгээр сар	-	-	2020 оноос шилжсэн ажил.	УУХҮЯ, Ажлын алба	Эрдэнэс Монгол ХХК дээр сургалт хийхээр хэлэлцэж хариу хүлээж байна.

Хоёрдугаар зорилгод шаардагдах мөнгөн дүн

Улсын төсөв Бусад эх үүсвэр

Гуравдугаар зорилго: Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны уян хатан нэгтгэл тайланг гаргах, тайланг хэлэлцэн батлах.

Үндэслэл: Дэлхий нийтээр тархаад буй Covid-19 цар тахлаас үүсэн нөхцөл байдлаас шалтгаалан ОУИТБС-ын Олон Улсын Удирдах хорооноос илүү хялбаршуулсан, уян хатан тайланг гаргах боломжтой талаар гишүүн орнууддаа зөвлөсөн. Энэхүү зөвлөгөөг дагаж мөрдөх шийдвэрийг ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн ажлын хэсгийн гишүүд дэмжсэний дагуу Монгол улс уян хатан нэгтгэл тайланг 2021 оноос эхлэн гаргана.

Хянан зохицуулах байгууллага: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА	ТӨСӨВ		Тайлбар	Хяналт тавих байгууллага	Биелэлт
					Мөнгөн дүн (мян.төг)	Эх үүсвэр			
Зорилт 7. Уян хатан нэгтгэл тайланг боловсруулах, батлах;	7.1. Уян хатан нэгтгэл тайланг боловсруулах Ажлын даалгаврыг ² батлах, зарлах, Үнэлгээний хороо байгуулах, Хараат бус хянагч, нэгтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээт ажлыг зохион байгуулах;	Хуулийн дагуу тендерийн бэлтгэл ажил хангагдсан байна.	Үнэлгээний хороо, Ажлын хэсэг	1-6 дугаар сар	45,000	Улсын төсөв		УУХҮЯ	Тендер дуусч, Грант Торнтон аудит ХХК шалгарсан, гэрээ байгуулсан, Ажил дуусч, Үндэсний зөвлөлд танилцуулж байна. Зардал: 49,593.5 төгрөг
	7.2. Уян хатан нэгтгэл тайлангийн ерөнхий мэдээллийг бэлтгэх Ажлын хэсгийг байгуулах, тайланг боловсруулах;	Тайлангийн хамрах хүрээ тодорхойлогдсон байна.	Ажлын хэсэг		1-9 дүгээр сар	5,000	Улсын төсөв		УУХҮЯ

² Зөвхөн зэсийн баяжмал, алт үйлдвэрлэгч компаниудын тайлангуудыг тулган баталгаажуулна.

	7.3. Тайлан, мэдээллийг танилцуулах, хэлэлцүүлэх, батлах;	Уян хатан тайланг баталсан байна.	Хараат бус хянан нэгтгэгч, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл	10-11 дүгээр сар	5,000	АХБ		УУХҮЯ	Хэлэлцүүлж байна.
--	---	-----------------------------------	---	------------------	-------	-----	--	-------	-------------------

Гуравдугаар зорилгод шаардагдах мөнгөн дүн

АХБ Улсын төсөв

Дөрөвдүгээр зорилго: Үндэсний болон орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлсний үр нөлөөг үнэлэх сайн туршлагыг баримтжуулах, Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийг ашиглах ач холбогдол, боловсруулах талаар сургалт сурталчилгааны ажлыг хөгжүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, аймаг бүс нутгаар бүтээгдэхүүн гаргаж түгээх

Үндэслэл: Олон улсын ОУИТБС-ын Удирдах хорооны зүгээс урт, дунд хугацаанд ОУИТБС-ын талаарх иргэд, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгыг тавиад байгаа билээ. Энэхүү зорилгын хүрээнд ОУИТБС-ын талаарх ойлголтыг олон нийтэд хүргэх, иргэдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгыг мөн гишүүн орнууд тавьж хэрэгжүүлэх шаардлагатай юм. Иймд олборлох үйлдвэрлэлийн мэдээлэл, харилцаа, сурталчилгааг идэвхжүүлэх замаар ОУИТБС-ын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, түүнчлэн 2021 оны баталгаажуулалтад бэлтгэх, 2018-2019 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмж, Үндэсний зөвлөлөөс гаргасан санал, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

Хянан зохицуулах байгууллага: Ажлын алба

ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА	ТӨСӨВ		Тайлбар	Хяналт тавих байгууллага	Биелэлт
					Мөнгөн дүн (мян.төг)	Эх үүсвэр			
Зорилт 8. ОУИТБ-ын тайлан, мэдээллийг иргэд олон нийтэд зориулан ойлгомжтой байдлаар боловсруулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх;	8.1. ОУИТБС-аас гаргаж буй мэдээлэл, тайлангийн хэрэгцээ шаардлагыг хэрэглэгчийн бүлэг ³ тус бүрээр тодорхойлж гаргах;	Мэдээллийн хэрэгцээ шаардлага тодорхой болсон байна	Ажлын алба, Судалгааны байгууллага	1-3 дугаар сар	25,000	Бусад эх үүсвэр	Мэдээллийн хэрэгцээний судалгаа хийх.	УУХҮЯ ИНБ	Харилцааны төлөвлөгөөний дагуу олон нийт, орон нутагт чиглэсэн хэрэгцээг тодорхойлж, маягтад өөрчлөлт оруулах саналууд өгсөн. Сумын түвшний илт тод байдлыг сайжруулах, орон нутгийн иргэдийн мэдээллийн хэрэгцээг гаргаж, хэрхэн хангах талаар ирэх оны төлөвлөгөөнд тусгасан.
	8.2. ОУИТБС-аас гаргаж буй тоон мэдээлэл, тайлан мэдээг хүртэгч, ашиглагч байгууллагуудын төлөөлөлийн зөвлөмжид үндэслэн тайлан мэдээллийг сайжруулах;	Тоон мэдээлэл ойлгомжтой, хялбар болсон байна, ОУИТБС-аас гарган хэвлэж буй тайлан, мэдээллийг ашиглагч байгууллагын төлөөлөл болох ОУСК-тай хамтран тайлан мэдээг олон нийтэд ойлгомжтой, хялбар болгохоор ажиллана		Ажлын алба, Олон улсын санхүүгийн корпораци	1-3 дугаар сар	-	-		УУХҮЯ ИНБ

³ Иргэд, ИНБ, компаниуд гэх мэт

									дүржүүлэлт хийж, сайтад байршуулахаар бэлтгэж байна.
	8.3. ОУИТБС-ын тайлан, мэдээллийг аймаг, бүс, улсын хэмжээнд олон нийтэд ойлгомжтой байдлаар боловсруулах, товч тайлан мэдээлэл гаргах, түгээх;	Өгөгдөлтэй ажиллах ОУСК-р бэлтгэгдсэн сургагч багш, сургалтад хамрагдсан дундын бүлэгтэй хамт тайлан мэдээллийг аймаг, бүс нутгийн хэмжээнд боловсруулан түгээх ажлыг хийнэ. Мөн орон нутгийн төрийн байгууллагуудын цахим сайтад байршуулах	Ажлын алба	3-8 дугаар сар	10,000	Улсын төсөв		УУХҮЯ	Харилцааны стратегийн хүрээнд төлөвлөгөөг гарган сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Малчдад бодит мэдээлэл хүргэх "Ил тод орон нутаг" сонин анхны дугаарыг туршилтын журмаар гаргахаар бэлтгэж байна. Энэ онд багтан хэвлэлтэд шилжүүлнэ.
	8.4. ОУИТБС-тай холбоотой тайлан, мэдээллийн цахим сайт, сувгуудыг нэгтгэж, мэдээллийн нэгдсэн бааз үүсгэх;	Мэдээллийн нэгдсэн бааз үүсгэгдсэн байна. Цахим тайлангийн вэб сайт, ОУИТБС-ын вэб сайт, гэрээний ил тод байдлын вэб сайтуудыг нэгтгэж нэгдсэн мэдээллийн бааз бий болгоно.	Ажлын алба	5-7 дугаар сар	45,000	Улсын төсөв		УУХҮЯ ИНБ	Харилцааны хүрээнд стратеги боловсруулсан ба ирэх оны ажлын төлөвлөгөөнд тусгасан.
Зорилт 9. Үндэсний түвшний мэдээлэл харилцааг идэвхжүүлэх;	9.1. Мэргэжлийн холбоодтой (МУУҮА, Нүүрс Ассоциац, МҮХАҮТ, МБЗ) хамтын ажиллагааг өргөжүүлэх, сургалт семинарыг цахим болон танхимаар зохион байгуулах;	Мэргэжлийн холбоодын мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.	Мэргэжлийн холбоод, Ажлын алба	6 дугаар сар	1,000	АХБ		УУХҮЯ	6-р сарын 7-нд эхний семинарыг зохион байгуулсан.
	9.2. Төрийн бус байгууллага, бодлогын хүрээлэнгүүд, Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, санал солилцох;	Тухайн байгууллагуудын мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.	Иргэний нийгмийн байгууллагууд, Ажлын алба	5 дугаар сар	1,000	АХБ	2020 оноос шилжсэн.	ҮҮХҮЯ ИНБ	8-р сарын 30-нд Сэтгүүлчдийн сургалт зохион байгуулсан. Зардал-1,029.3 мян.төг
	9.3. УИХ-ын Эдийн засаг, Төсвийн байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд Монгол Улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн үр нөлөө, ач холбогдол, цаашдын зорилтыг танилцуулах;	УИХ-ын гишүүдийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.	Ажлын алба	2-4 дүгээр сар	-	-	2020 оноос шилжсэн.	УУХҮЯ	2021-11-16 УИХ дээр хуулийн хэлэлцүүлэг хойшилсон.
	9.4. Орон нутгуудын төр захиргааны байгууллагууд, тэдгээрийн удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдийг тогтмол мэдээллээр хангах, харилцан мэдээлэл солилцох цахим сургалтуудыг зохион байгуулах;	Орон нутгууд дахь байгууллагуудын мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.	Иргэний нийгмийн байгууллагууд, Ажлын алба	4-6 дугаар сар	-	-		УУХҮЯ	2 сар тутам цахимаар уулзаж, мэдээлэл солилцож байна. ИНБ хувь нэмрээ оруулж байна.
Зорилт 10. Орон нутгийн түвшинд иргэдэд мэдлэг ойлголт өгөх, үйл ажиллагааг сурталчилан	10.1. Бүс, орон нутагт ОУИТБС-ыг сурталчлах, олон нийтэд таниулахад тухайн орон нутгууд	Орон нутгууд дахь ИНБ-ийн нийгмийн, оролцоо нэмэгдэнэ.	Иргэний нийгмийн байгууллагууд, Ажлын алба	3-10 дугаар сар	-	-		УУХҮЯ	Ил тод аймаг туршилтын төслийг УУХҮЯ, ИНБ, ОУСК-

таниулах, оролцоог хөхиүлэн дэмжих, хамтын ажиллагаа түншлэлийн хэлбэрүүд бий болгох	дахь Иргэний нийгэм, ТББ-уудтай хамтарч ажиллах, хэвтээ болон босоо сүлжээ түншлэлийг хөгжүүлэх, дэмжих загвар удирдамж гаргах;	ИНБ, ОУИТБС-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулснаар иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдэх боломжтой.							тай хамтран Говийн бүсийн аймгуудад эхлүүлсэн.
	10.2. ОУИТБС-ын талаар орон нутаг, бүс нутгийн хэмжээнд харилцаа, мэдээллийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, цахим хурлуудыг зохион байгуулах;	Орон нутаг, бүс нутгийн хэмжээнд ОУИТБС-ын талаарх ойлголт нэмэгдэнэ.	Иргэний нийгмийн байгууллагууд, Ажлын алба	4-11 дүгээр сар			-	УУХҮЯ	2 сар тутам цахимаар уулзаж, мэдээлэл солилцож байна. ИНБ-ууд хувь нэмрээ оруулж байна.
	10.3. Орон нутаг дахь олборлох салбарын аж ахуйн нэгжүүд ИТХ, иргэдийн дунд БОМТ-ий хэрэгжилтээ тайлагнах, иргэдийг мэдээллээр хангах арга хэмжээг зохион байгуулах;	Орон нутаг дахь аж ахуйн нэгжүүдийн хариуцлага, ил тод байдал, иргэдийн ойлголт нэмэгдэнэ.	Дэд зөвлөлүүд, ТББ, Ажлын алба	6-10 дугаар сар	20,000		АХБ	УУХҮЯ	1800 компанид цахим шуудан явуулж, тайлангаа ил тод болгохыг хүссэн. Одоогоор 20 компани мэдээллээ ирүүлсэн байна.
	10.4. УУХҮЯ болон аймгийн Засаг дарга нарын үр дүнгийн гэрээ, Аймаг сумын удирдлага болон сумын Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд ОУИТБС-тай холбоотой томоохон ажлуудыг тусгах, үр дүнгээр хариуцлагуулах, урамшуулах тогтолцоог бий болгох;	Үр дүнгийн гэрээнд тусгагдаж, орон нутгийн хариуцлага нэмэгдэнэ.	УУХҮЯ, Ажлын алба, ТББ	1-3 дугаар сар			-	Уг заалтыг УУХҮЯ, ЗД нарын үр дүнгийн гэрээнд тусгах.	УУХҮЯ
Зорилт 11. ОУ-ийн мэдээлэл, харилцаа, сурталчилгааны ажил, хэвлэн нийтлэх материал боловсруулах, хэвлэн түгээх;	11.1. ОУ-ийн мэдээлэл, харилцаа, сурталчилгааны стратегийн дагуу ажлын төлөвлөгөө боловсруулан, батлуулах ⁴ ;	Мэдээлэл, харилцаа, сурталчилгаа-ны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болно.	Ажлын алба	2-3 дугаар сар			-	УУХҮЯ	Харилцааны төлөвлөгөөний хүрээнд бэлтгэж байна.
	11.2. Харилцаа, мэдээллийн ажлыг гүйцэтгэх PR-ын зөвлөх үйлчилгээ авах;	Харилцаа, мэдээллийн ажлын чанар сайжрах.	Ажлын алба	6-12 дугаар сар	27,000		Бусад эх үүсвэр	УУХҮЯ	2022 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан.
	11.3. Сургалт, сурталчилгаа, үзэсгэлэн, бага хурал, уулзалтуудад зориулан хэвлэмэл бүтээгдэхүүн бэлтгэх, хэвлүүлэх;	Олон нийт мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	Ажлын алба	8-12 дугаар сар	5,000		Улсын төсөв	УУХҮЯ	Харилцааны төлөвлөгөөний хүрээнд төлөвлөгөө гаргаж, ирэх оны зураглалыг гаргасан.
	11.4. Өдөр тутмын сонин, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааны ажлууд, хэлэлцүүлэг зохион байгуулах;	Олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.	Ажлын алба	2-12 дугаар сар	15,000		Улсын төсөв	УУХҮЯ	Цаг үеийн шинжтэй мэдээ мэдээллүүд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээгдэж байгаа, өгөгдөл ашигласан мэдээлэл сурталчилгааг бэлтгэн түгээх ажлыг

⁴ Тусдаа ажлын төлөвлөгөө гаргана.

									графикийн дагуу хийж байгаа. Зардал-770.0 мян.төгрөг Жш; Хандив дэмжлэг, эцсийн өмчлөгчдийн мэдээлэл гэх мэт
	11.5. Нийгмийн сүлжээнүүдийг ашиглан ОУИТБС-ыг олон нийтэд сурталчилах;	Олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.	Ажлын алба	2-10 дугаар сар	-	-		УУХҮЯ	Facebook- т холбогдох мэдээллийг байршуулан сурталчилж байна
	11.6. Жишиг сумдын туршлагыг баримтжуулж, богино хэмжээний видео нэвтрүүлэг хийн олон нийтэд түгээх;	Олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.	Ажлын алба	4-10 дугаар сар	5,000	Улсын төсөв		УУХҮЯ	2022 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан байна.
	11.7. ОУИТБС-ын талаарх ойлголтыг олон нийтэд хүргэх чиглэлээр Иргэний нийгэм, ТББ-уудтай хамтарч ажиллах;	Олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.	Ажлын алба	3-8 дугаар сар	-	-		УУХҮЯ	ИНБ-тай хамтран ажиллаж байна. ИНБ, ХМХ-ийн ойлголтыг нэмэгдүүлж, өгөгдөл ашиглах ур чадварыг сайжруулах сургалтын төлөвлөгөө боловсруулаад байна.
Зорилт 12. 2022 оны баталгаажуулалтад бэлтгэх;	12.1. ОУИТБС-ын 2019 оны стандартын шаардлага бүрээр өөрийн үнэлгээ хийх, дүнг хэлэлцэх, авах арга хэмжээний төлөвлөгөө гаргах;	Баталгаажуулалтын бэлтгэл ажил хангасан байна.	ОТӨАХ	9-12 дугаар сар	1,000	Улсын төсөв		УУХҮЯ	Баталгаажуулалтын цуврал семинарыг ОУНБГ-тай хамтран зохион байгуулсан. Холбогдох материалуудыг хүргүүлсэн.

Дөрөвдүгээр зорилгод шаардагдах мөнгөн дүн

АХБ Улсын төсөв Бусад эх үүсвэр

Тавдугаар зорилго: Дэд зөвлөлүүдийг чадавхжуулах.

Үндэслэл: Үндэсний зөвлөлөөс баталсаны дагуу 2019 болон 2020 оныг дэд зөвлөлүүдийг чадавхжуулах жил болгон зарласан билээ. Гэвч 2020 оны ажлын төлөвлөгөөн дээр тусгайлсан Дэд зөвлөлийг чадавхжуулах зорилго, зорилтууд тусгагдаагүй байсан. Мөн Covid-19 цар тахлын улмаас үүссэн хорио цээр, УИХ, орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаанаас үүдэн дэд зөвлөлийг чадавхжуулах арга хэмжээг дорвитой хэрэгжүүлж чадаагүй. Иймд 2021 онд дэд зөвлөлийг чадавхжуулах тусгайлсан зорилго, зорилт дэвшүүлж байна. Тус зорилтын хүрээнд эхний ээлжинд Өмнийн говийн бүсийн аймгууд дахь дэд зөвлөлүүдийг чадавхжуулна.

Хянан зохицуулах байгууллага: Ажлын алба

ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА	ТӨСӨВ		Тайлбар	Хяналт тавих байгууллага	Биелэлт
					Мөнгөн дүн (мян.төг)	Эх үүсвэр			
Зорилт 13. Дэд зөвлөлүүдийг чадавхжуулах хэрэгцээний суурь судалгаа, стратеги боловсруулах;	13.1. ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, чадавхи хэрэгцээний суурь судалгаа, мониторинг хийх ⁵ ;	Хэрэгцээний шаардлага тодорхой болж, дэд зөвлөлүүдийг чадавхжуулах суурь судалгаатай болсон байна.	Үнэлгээний хороо, Ажлын алба	1-3 дугаар сар	10,000	Улсын төсөв	ДЗ-ажил явахгүй байгааг тодорхойлж, чадавхийг бэхжүүлэх	УУХҮЯ ИНБ	Тендерт Хүний хөгжил, сургалтын төв шалгарч, гэрээ байгуулсан, ажил дууссан. 09-30, 11.

⁵ Ажлын даалгаврыг батлах, зарлах,

	13.2. Дэд зөвлөлүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх стратеги, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;	Стратеги, төлөвлөгөөний дагуу чадавх бэхжсэн байна		3-12 дугаар сар			судалгааг хийх, төлөвлөгөө боловсруулна.		30 нд АХ-д явцаа танилцуулсан. Зардал-9.359.5 мян.төгрөг
	13.3 Аймгийн дэд зөвлөлүүд 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулах ⁶ ,	Үйл ажилаагааны хөтөлбөр тодорхой болсон байна.	Аймгуудын ЗДТГ, Ажлын алба	2-3 дугаар сар	-	-	Зарцуулалтыг аймгийн цахим хуудасны шилэн дансаар нээлттэй болгох.	УУХҮЯ СЯ Ажлын алба	Аймгууд 2021 оны төлөвлөгөөгөө боловсруулсан. 11 аймаг төлөвлөгөөгөө ирүүлсэн.
Зорилт 14. Дэд зөвлөлүүдийг чадавхжуулах сургалт, семинарын үйл ажиллагааг чанаржуулах;	14.1. Дэд зөвлөлүүдтэй хийх сургалт, семинарыг тогтмолжуулж, харилцан туршлага судлах-цахим;	Дэд зөвлөлүүдийн туршлага нэмэгдэж, үйл ажиллагаа нь идэвхжсэн байна	Аймгуудын ЗДТГ, Ажлын алба	2 сар тутам				Ажлын алба	2 сар тутам цахимаар уулзаж, мэдээлэл солилцож байна.
	14.2. Өмнийн бүс дэх дэд зөвлөлүүдийг чадавх бэхжүүлэх сургалт, семинарт хамруулах, мэдлэг, мэдээллээр хангах	Дэд зөвлөлүүдийн мэдлэг, чадавх нэмэгдсэн байна	Өмнийн бүсийн аймгуудын ЗДТГ, Ажлын алба, Иргэний нийгэм, Төрийн бус байгууллагууд, сургалт зохион байгуулагч байгууллагууд	Улирал тутам	50,000	АХБ, (ОУСК)	ИНБ, ТББ, ОУСК ийн сургалтуудад дэд зөвлөлүүдийг хамруулах. сургагч багш бэлтгэх.	Ажлын алба	2021 оны 10-р сарын 29-нд цахимаар зохион байгуулсан. 4 аймаг оролцсон. Зардал-300.0 мян.төгрөг
	14.3. ОУИТБС-ын гишүүн бусад улсуудын туршлагаас суралцах, сургалт семинарт оролцох;	ОУИТБС-ын Ажлын алба, Ажлын хэсгийн гишүүд, Дэд зөвлөлийн туршлага, мэдлэг сайжирсан байна.	УУХҮЯ, Ажлын алба, ИНБ, Дэд зөвлөл	10-12 дугаар сар	30,000	АХБ			Хойшилсон
Зорилт 15. Бүс нутгуудад чуулган семинарууд зохион байгуулж, дэд зөвлөлүүдийн чадавхийг бэхжүүлэх;	15.1. Төвийн бүсийн чуулган, сургалтыг Булган аймагт (8 аймаг, 100 хүн) зохион байгуулах, туршлага солилцох;	Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхжсэн байна.	Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба	6 дугаар сар	20,000	АХБ	2020 оноос шилжсэн ажил.	УУХҮЯ	Цахимаар 5-р сарын 27-28-нд зохион байгуулсан. 90 гаруй хүн оролцсон. Хурлаас зөвлөмж гарсан. Зардал - 416.9 мян. төгрөг
	15.2. Баруун бүсийн чуулган, сургалтыг Завхан аймагт /5 аймаг, 100 хүн/ зохион байгуулах, туршлага солилцох;	Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхжсэн байна.	Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба	8 дугаар сар	20,000	АХБ	2020 оноос шилжсэн ажил.	УУХҮЯ	Цахимаар 10-р сарын 26-27-д зохион байгуулсан. 6 аймаг оролцсон. Зардал- 618.9 мян.төгрөг

⁶ Аймаг бүр Нийтийн сонсголын хуулийн дагуу ерөнхий болон төсвийн хяналтын сонсгол явуулах замаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар тэдний саналд үндэслэн аймгийн дэд зөвлөлүүд 2021 оны төлөвлөгөөндөө оруулах;

	15.3. Зүүн бүсийн чуулган, сургалтыг Сүхбаатар аймагт /3 аймаг, 100 хүн/ зохион байгуулах, туршлага солилцох;	Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхэжсэн байна.	Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба	9 дүгээр сар	20,000	АХБ		УУХҮЯ	12-р сарын 14-нд Зүүн бүсийн чуулганыг цахимаар зохион байгуулсан. Зардал- 200 мян. төгрөг
	15.4. Өмнөд бүсийн чуулган, сургалтыг Өмнөговь аймагт /5 аймаг, 100 хүн/ зохион байгуулах, туршлага солилцох;	Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхэжсэн байна.	Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба	10 дугаар сар	20,000	АХБ		УУХҮЯ	2022 онд зохион байгуулахаар хойшлуулсан.

Тавдугаар зорилгод шаардагдах мөнгөн дүн

Улсын төсөв: АХБ:

Зургаадугаар зорилго: Ашиг хүртэгч жинхэнэ эздийн ил тод байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, бүртгэлийн тогтолцоог сайжруулах, туршилтаар мэдээлэл цуглуулах, ОУИТБС-ын хүрээнд авлигын эрсдэлийг тодорхойлох төслийг хэрэгжүүлэх.

Үндэслэл: ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс 2016 онд баталсан Замын зургийн дагуу ажлуудаа хэрэгжүүлж байна. Улсын бүртгэлийн тухай хуульд 2018 оны 11 дүгээр сард нэмэлт өөрчлөлт орсны дагуу Монгол улсад бүртгэлтэй бүх хуулийн этгээдүүдийн хувь эзэмшигчдийн мэдээлэл олон нийтэд ил тод болох боломжтой болсон. Гэсэн хэдий ч тус мэдээллийг цуглуулж буй төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, ашиг хүртэгч эцсийн эзэн мөн эсэхийг баталгаажуулах, цахим системийг сайжруулах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зэрэг Замын зурагт тусгасан үлдсэн ажлуудаас 2021 онд хэрэгжүүлэх шаардлага бий. ОУИТБС-ын хүрээнд бий болсон мэдээллийг аливаа эрсдэл, түүний дотор авилгын эрсдэлийг тодорхойлоход ашиглахыг цаг үе шаардаж байна.

Хянан зохицуулах байгууллага: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА	ТӨСӨВ		Тайлбар	Хяналт тавих байгууллага	Биелэлт
					Мөнгөн дүн (мян.төг)	Эх үүсвэр			
Зорилт 16. Монгол Улсын ОУИТБС-ын 2013-2019 оны тайлангуудаар ил болсон ашиг хүртэгч эцсийн эздийн мэдээллийг ашиглах, түгээх;	16.1. Засгийн газрын байгууллагуудын Ажлын хэсгийг байгуулан, улирал бүр нэг удаа зөвлөлдөх;	АХЖЭ-ийн ил тод байдлын үйл ажиллагаагаа уялдуулна.	Ажлын алба	3-12 дугаар сар	1,000	АХБ	2020 оноос шилжсэн ажил.	УУХҮЯ	Мэдээллийг бэлтгэж 8-р сарын 26-ны ОУ-ын вебинарт давхар танилцуулсан.
Зорилт 17. Ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийг цуглуулах системийг хөгжүүлэх, мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаажуулах институтыг бэхжүүлэх;	17.1. УБЕГ, АМГТГ, ТЕГ-тай хамтран чадавх бэхжүүлэх, хяналт хариуцлагын хөшүүрэг хэрэгжүүлэх сургалт/нөлөөлөл хийх зохион байгуулах- цахим ⁷ ;	Төрийн байгууллагын чадавх сайжирсан байна.	Ажлын алба	5 дугаар сар	1,000	АХБ	2020 оноос шилжсэн ажил.	УУХҮЯ	2022 онд зохион байгуулахаар хойшлуулсан.
	17.2. АХЖЭ-ийн мэдээллийг бүртгэдэг, хүлээн авдаг Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран тайлан гаргахад аргагүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах- цахим ⁸ ;	Мэдээлэл цуглуулах, солилцох механизм боловсронгуй болсон байна.	Ажлын алба	6 дугаар сар	1,000	АХБ	2020 оноос шилжсэн ажил.	УУХҮЯ	2022 онд зохион байгуулахаар хойшлуулсан.
Зорилт 18. ОУИТБС-ын хүрээнд Авлигын эрсдэлийг тодорхойлох хэрэгслийг боловсруулж; туршилтын төслийг хэрэгжүүлэх;	18.1. Авлигын эрсдэлийг тодорхойлох хэрэгслийг орчуулах, ОУИТБС-ын Ажлын хэсэгт танилцуулах, үнэлгээ хийх цар хүрээг тодорхойлох;	Авлигын эрсдэлийн үнэлгээний арга зүйг ОУИТБС-ын хэрэгцээнд нийцүүлсэн байна.	ББЗХ, Ажлын алба	2 дугаар сар	2,000	Бусад эх үүсвэр /ББЗХ (ГОУХАН) /	Ажлын хэсгийн 52 дугаар хуралдаа наас гарсан саналын дагуу тусгагдав.	Ажлын хэсэг (Ажлын хэсгийн гишүүдээс бүрдсэн хороо)	Ажлын хэсэгт танилцуулж, Ажлын дэд хэсгийг 2-р сард байгуулсан. Дэд хэсэг 3 удаа хуралдсан. Эхний дүнгээ 6-р сарын 30-нд Ажлын хэсэгт танилцуулсан. 9-р
	18.2. Авлигын эрсдэлийг тодорхойлох хэрэгслийг ашиглан үнэлгээ хийх;	Үнэлгээ хийгдсэн байна.	ББЗХ	2-5 дугаар сар	5,000				

⁷ ОУИТБС-ын ОУНБГ-тай хамтарна.

⁸ ОУИТБС-ын ОУНБГ-тай хамтарна.

	18.3 Үнэлгээний үр дүнг Ажлын хэсгээр хэлэлцүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах;		ББЗХ, Ажлын алба	6 дугаар сар	1,000				сарын 30-нд эцсийн байдлаар танилцуулсан.
Зургаадугаар зорилтод шаардагдах мөнгөн дүн					11,000	АХБ: Бусад эх үүсвэр;			

ОУИТБС-ын 2018-2019 оны нэгтгэл тайлангуудад тусгагдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

Зорилт 19. 2018, 2019 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	19.1. Олборлох салбартай холбоотой мэдээллийг УУХҮЯ-д төвлөрүүлэх, мэдээллийг хянаж, шалгасны дараа бусад Засгийн газрын байгууллагад түгээж байх;	Мэдээллийн зөрүүтэй байдал арилна.	Ажлын алба	12 дугаар сар	-	-	2020 оноос шилжсэн ажил.	УУХҮЯ	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.
	19.2. Орон нутгийн холбогдох төрийн байгууллагуудын хүлээн авсан хандивын мэдээллийг иж бүрнээр цахим сайтад байршуулах; аймгийн аудитын газар сангууд, хандивын асуудалд аудит хийх.	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Холбогдох аймгуудын ЗДТГ	9 дүгээр сар	-	-	2020 оноос шилжсэн ажил.	Аймгийн Аудит-ын газар УУХҮЯ	Аймгуудад албан тоот явуулсан.
	19.3. Аудитлагдсан санхүүгийн тайлангуудыг ОУИТБС-ын вэбсайт дээр тусад нь байршуулах;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	7 дугаар сар	-	-		УУХҮЯ	ОУИТБС-ын цахим тайлагналын систем дээр шалгана.
	19.4. ТӨААН-ийн ТУЗ-ийн гишүүдийг ил болгох, хөндлөнгийн хараат бус гишүүдийг сонгож байгаа аргачлал, журмыг олон нийтэд мэдээлэх;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	8 дугаар сар	-	-		УУХҮЯ	Төрийн өмчийн компаниудад албан тоот явуулсан бөгөөд Компаниуд дэмжсэн хариу ирүүлсэн.
	19.5. ТӨААН-ийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг нээлттэй болгох;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	8 дугаар сар	-	-		УУХҮЯ	Төрийн өмчийн компаниудад албан тоот явуулсан бөгөөд Компаниуд дэмжсэн хариу ирүүлсэн.
	19.6. Компаниудын БОННУ, Менежментийн төлөвлөгөө, тайланг ОУИТБС-ын веб сайт дээр байршуулах;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	Ажлын алба	6 дугаар сар	-	-		УУХҮЯ	1800 компаниудад цахим шуудан явуулсан. 20 компани мэдээллээ ирүүлсэн.
	19.7. Боловсруулах салбарын томоохон үйлдвэрлэгч болон туслан гүйцэтгэгч нарыг ОТАХ судалж, улсын төсөвт томоохон хувь нэмэр оруулж буй компаниудыг урьдчилан сонгож, тэдэнд албан ёсоор мэдэгдэж, цахим тайлангийн системд үндсэн мэдээллийг оруулснаар, ил тодын тайланг тушаах нөхцлийг бүрдүүлж, улмаар ОУИТБС-ын нэгтгэлд хамруулах;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Ажлын алба	8 дугаар сар			2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ	2022 онруу хойшилсон
	19.8. Компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайланг тушааж хэвшүүлэх, тушаасан тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах талаар жил жилийн нэгтгэлийн тайлангаар зөвлөмж өгдөг боловч энэ тал дээр томоохон ахиц харагдахгүй байгаа	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Ажлын алба	8 дугаар сар			2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд оруулсан.

	нь Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийг баталж мөрдүүлэх нь чухал болохыг харуулж байна.								
	19.9. Хуулийн өөрчлөлт нь ТЕГ-ын алтны компаниудын АМНАТ-ын ногдуулалт, төлөлтийн горимд нөлөөлсөн боловч ОУИТБС-ын тайлангаа зөв дүнгээр тайлагнах, АМНАТ-ын ногдуулалт, төлөлтийн байдалд тавих хяналтад нөлөөлөхгүй тул ТЕГ нь мэдээллийн системээ сайжруулж, ОУИТБС-ын тайлангаа үнэн зөв тайлагнах тал дээр цаашид анхаарах;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Татварын ерөнхий газар	6 дугаар сар			2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ	2022 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан байна.
	19.10. АМГТГ-ын кадастрын систем, ОУИТБС-ын цахим систем дэх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгаж, нэг эх үүсвэртэй мэдээлэл дээр цахим тайлангийн системийг ажиллуулах, хөдөө орон нутагт олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийг кадастрын системд цаг алдалгүй оруулж, олон нийтэд мэдээлж байх;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Ашигт малтмал, Газрын тосны газар, Ажлын алба	1-2 дугаар сар, жилдээ			2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ	Аймгуудад албан тоот явуулсан. 10 аймаг л хариу ирүүлсэн. Ямар нэг зөрүү байхгүй гэсэн хариу түгээмэл байна.
	19.11. Цахимаар авч байгаа мэдээллийг оролцогч талууд баталгаажуулах, бүгдийг олон нийтэд ил тод болгох, эсвэл сонгогдсон компаниудын мэдээллийг хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс үнэлж, сайжруулан олон нийтэд ил тод болгох;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Ажлын алба	12 дугаар сар			2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ	2021 оны нэгтгэл тайланд оруулах боломжийг судална.
	19.12. Олборлох салбарын бүх ТӨААН-ийн аудитлагдсан иж бүрэн санхүүгийн тайланг цахимаар нийтэд мэдээлэх, тухайн ТӨААН-ийн вэб хуудсанд болон ҮАГ, ОУИТБС, АМГТГ-ын вэб хуудсанд тус тус нийтлэх;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Холбогдох ТӨААН-ууд	6 дугаар сар			2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ	Төрийн өмчийн компаниудад албан тоот явуулсан бөгөөд Компаниуд дэмжсэн хариу ирүүлсэн.
	19.13. ТӨААН-үүдийг шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ ил тод оруулах, ТӨБЗГ-ын цахим хуудсаар ТӨААН-с хүлээн авсан ногдол ашиг, хамаарах төрийн байгууллагын вебсайтаар дамжуулан ил тод болгон нийтэлж байх тогтолцоог бий болгох;	Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна	Холбогдох ТӨААН-ууд	6 дугаар сар			2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ	Төрийн өмчийн компаниудад албан тоот явуулсан бөгөөд Компаниуд дэмжсэн хариу ирүүлсэн.

	<p>19.14. Цаашид Хараат бус хянагч нэгтгэгчийн оролцоо багасах үед тоо мэдээний чанар, үнэн зөв байдал улам илүү тавигдах болно гэдгийн үйл ажиллагаандаа анхаарч ажиллахыг зөвлөж байна. Үүнд:</p> <p>1. Хамгийн их зөрүү гаргаж буй, мэдээллээ ил тод нийтлэхгүй, тайлагналын хариуцлага хүлээхгүй байгаа байгууллагад сургалт зааварчилгаа өгөх, нөлөөллийн арга хэмжээнүүд авах.</p> <p>2. Монголын ОУИТБС-ын 2019 оны нэгтгэлийн тайланг албан бичгийн хамт хүргүүлж, цаашид хэрхэн хамтарч ажиллахыг зөвлөх.</p> <p>3. ОУИТБС-ын Ажлын албаны вэбсайт дахь мэдээ, мэдээллийг байнга шинэчлэх.</p>	<p>Тайлан цаг хугацаандаа гарсан байна.</p>	Ажлын алба	6 дугаар сар			2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ	<p>2019 оны ОУИТБС-ын тайланг цахим сайт дээр байршуулсан.</p> <p>2019 оны ОУИТБС-ын тайланг цахим сайт дээр байршуулсан.</p> <p>Веб сайтын мэдээллийг тухай бүр шинэчилж байна.</p>
		<p>Тайлангийн чанар сайжирсан байна.</p>	Ажлын алба	2 дугаар сар					
		<p>Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.</p>	Ажлын алба	Жилдээ					
	<p>19.15. ОТАХ-ийн зүгээс тендер зарлах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа төрийн хууль тогтоомжийг чанд мөрдөж, төлөвлөгөөт цаг хугацаандаа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байхад хяналт тавьж, дүрэм журмыг чанд мөрдөж ажиллах;</p>	<p>Богино хугацаанд тендерийн шалгаруулт зохион байгуулдаг болно.</p>	Ажлын алба	8 дугаар сар				2019 оны нэгтгэл тайлангийн зөвлөмж	УУХҮЯ
Нийт зардлын дүн				92,888.1	АХБ: 2,365.1 төгрөг		Улсын төсөв: 90,523.0 төгрөг		

ОУИТБС-ын Ажлын алба